

ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 72 дугаар тогтоолд “төмөр замын тээврийн үйл ажиллагаатай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байх”-аар тус тус заасан.

Улсын Их Хурлын 2023 оны 72 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хэсэг”-т “Төмөр замын газар” байхаар нэмж тусгасан боловч Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар бүдүүвчийг шинэчлэн батлахдаа Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газрыг тусгалгүй орхигдуулсан.

Төмөр замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хууль батлагдаж байх үед буюу 2023 онд үндэсний төмөр замын сүлжээний урт 2965 км болж, 40 орчим хувиар нэмэгдсэн. Тухайлбал, Зүүнбаян-Ханги, Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн нийт 876.4 км төмөр замын бүтээн байгуулалтын барилгын ажил дуусч, төмөр замаар хийх экспортын хоёр болон гурав дахь гарцууд нээгдэхэд бэлэн болж, цаашид ч төмөр замын сүлжээ улам өргөжиж, гарцууд нэмэгдэх төлөвтэй байна.

Монгол Улсад төмөр замууд шинээр баригдаж байгаатай холбогдуулан суурь бүтцүүдийн хоорондын харилцааг зохицуулах зайлшгүй шаардлага бий болсон. Тухайлбал, одоо байгаа эрх зүйн орчны хүрээнд суурь бүтцүүдийн хооронд ачааны хэмжээг суурь бүтэц эзэмшигч нар хоорондоо тохиролцдог бөгөөд ингэхдээ аль нэг талын эрх ашгийн давуу байдалтай шийдвэрлэгдэж ирсэн.

Төмөр замын тухай хуулийн шинэчилсэн найруулгад суурь бүтцүүдийн хооронд солилцох ачааны төрөл, хэмжээг тогтоох, түүнд хяналт тавих, суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн удирдлагаар хангах, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хоорондын харилцааг зохицуулах, хэрэгжилтийг хангуулах зэрэг төрийн зайлшгүй зохицуулах чиг үүргийг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр тусгасан юм.

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээн дэх “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” Улсын төсөв үйлдвэрийн газар нь өсөн нэмэгдсээр байгаа тээврийн хэрэгцээг хангах, төмөр замын суурь бүтцүүдийн галт тэрэгний хөдөлгөөний зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах, суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч хооронд болон суурь бүтцийн үйлчилгээ үзүүлэгч, тээвэрлэгч хоорондын харилцааг зохицуулах, төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангах, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний паркийг шинэчлэх, тээврийн сүлжээг өргөжүүлэх, төмөр замын чиглэлийн судалгаа, шинжилгээ, шинжлэх ухаан, технологи, инновацийг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, төмөр замын салбарт мөрдөх дүрэм, журам, стандартыг боловсронгуй болгох, төмөр замын тээврийн үйлчилгээнд оролцогч өмчийн олон

хэлбэрийн хуулийн этгээдийн зах зээлийн өрсөлдөөний тэгш байдлыг хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх зэрэг үйл ажиллагааг өнөөгийн нөхцөл байдалд хэрэгжүүлэх боломжгүй болсон.

ОХУ, БНХАУ болон төмөр замын чиглэлээр идэвхитэй харилцдаг бусад улс орнууд төмөр замын тээврийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын агентлаг буюу Төмөр замын газартай байдаг.

Өнөөгийн байдлаар Монгол Улс хөрш орнуудтай ижил түвшний байгууллага байхгүйгээс тус үүргийг “Улаанбаатар төмөр зам” ХНН гүйцэтгэсээр ирлээ.

Ийм цаашид Зам, тээврийн яам болон “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын орон тоо болон материалаг нөөцийг ашиглан төсөвт дарамт учруулахгүйгээр Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан төрийн зохицуулалт, үйлчилгээ болон хяналтыг хэрэгжүүлэх Төмөр замын газрыг байгуулан үйл ажиллагаа явуулах бүрэн боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР